



# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

**Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчин  
бүрдээгүй байна.**



**Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн  
гүйцэтгэлийн аудитын тайлан  
/ДУАГ-ГАБ/2016/01-ГА/**

## АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Дундговь аймгийн Аудитын газар	Тайлангийн хураангуй	4-5
	Аудитын тухай	6-8
Тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг	• Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	6
	• Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт	6
	• Аудитын зорилго, хамрах хүрээ	7
	• Аудитын хандлага ба арга зүй	7-8
	• Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа	8
Аудитын менежер Х.Наранцацрал	• Ерөнхий мэдээлэл	8
	<b>Бүлэг 1: Үдийн цай хөтөлбөрийн тооцоо, судалгааг үнэн зөв бодитой хийсэн байна.</b>	
Ахлах шинжээч Ч.Бэрхсайхан	<i>1.1 Үдийн цай хөтөлбөрийн төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн байна.</i>	9-11
	<i>1.2 Үдийн цай хөтөлбөрийн гүйцэтгэлийг бодитой тооцож тайлагнасан байна.</i>	11-12
Шинжээч Д.Должинсүрэн	<b>Бүлэг 2: Үдийн цай хөтөлбөрийн хооллох орчин бүрдээгүй байна.</b>	
	<i>2.1 Хоол бэлтгэж буй газар болон хооллох орчин стандарт, эрүүл ахуйн шаардлага хангаагүй байна.</i>	13-18
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утсаар харилцана уу.	<i>2.2 Хүнсний бүтээгдэхүүн стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.</i>	19-22
	<b>Бүлэг 3: Үдийн цайг үдийн хоол болгон хэрэгжүүлсэн нь оновчтой шийдэл боловч эрх зүйн орчин бүрдээгүй байна.</b>	
ХАЯГ:	<i>3.1 Үдийн цай хөтөлбөрийг цаашид сайжруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.</i>	23-26
	<i>3.2 Үдийн цайны чанарт тавих хяналтад эцэг эхийн оролцоо хангалтгүй байна.</i>	26-27
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 214 тоот	<b>Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал</b>	28
	<b>Дүгнэлт</b>	29
	<b>Зөвлөмж</b>	30
	<b>Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал тайлбар</b>	31
	<b>Тайлан баталгаажуулсан тушаал</b>	32-34
2016 оны 11 дүгээр сар	Тайлангийн хавсралтууд	35-38

# Т

## ОВЧИЛСОН ҮГС

---

УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ҮАГ	Үндэсний Аудитын газар
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭДЦС	Эрдмийн далай цогцолбор сургууль
ГИЦС	Говийн ирээдүй цогцолбор сургууль

## Т АЙЛАНГИЙН ХУРААНГУЙ:

Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор 2013 оны эхнээс нэг суралцагчийн үдийн цайнд өдөрт 600 төгрөгийг зарцуулахаар баталсан. Дундговь аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 19 сургуулиас I-V ангийн суралцагчтай 18 сургуульд үдийн цайг хэрэгжүүлж байна.

Үдийн цай хөтөлбөрийн жилийн төсвийг үндэслэлтэй төлөвлөж байгаа ч хүүхдийн ирцийн тоонд үндэслэн хоолоо бэлтгэж чадахгүй байна.

Энэ нь тухайн өдөр хэдэн хүүхэд ирэхийг урьдчилан мэдэх боломжгүй, хичээл эхлээд ирц авсны дараа хоол бэлтгэхэд хугацаандаа амждаггүй, тогоочийн ажлын ачаалал их байдагтай холбоотой байна.

Сургуулиуд хүүхдийн ирцийн тоонд үндэслэн хоол бэлтгэх нь хөтөлбөрийн зардал бодитой тооцогдох учраас олон хүүхэдтэй сургуульд туслах тогооч ажиллах зайлшгүй шаардлага гарч байна. Иймд энэ асуудлыг судалж, шийдвэрлэх талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд санал хүргүүлсэн.

Үдийн цай хөтөлбөрөөр нийлүүлж байгаа хүнсний бүтээгдэхүүн эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа ч сумдын алслагдсан байдал, суманд үйлдвэрлэгч байхгүй зэргээс татан авалтыг богино хугацаагаар хийж чадахгүй, бүтээгдэхүүний хадгалалтын горим алдагдах эрсдэлтэй байна.

Энэ асуудалтай холбоотойгоор орон нутагт жижиг дунд үйлдвэрийг дэмжих бодлогын хүрээнд суманд үйлдвэрлэх боломжтой хүнсний бүтээгдэхүүний талаар судалж, сум хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний чиглэлд оруулан үдийн цай хөтөлбөртэй уялдуулах, сумдын бусад байгууллагын хүнсний материалыг хангаж ажиллах боломжийг судлах талаар Хүнс, хөдөө аж ахуйн газарт зөвлөмж хүргүүлсэн.

Суралцагчдын гар угаалт, аяга, халбаганы ариун цэвэр хангалтгүй, хооллох орчин нөхцөл бүрдээгүй байна.

Сумдын сургуулиуд төвлөрсөн цэвэр, бохир усанд холбогдоогүй, угаалтуурын тоо хүрэлцээгүйгээс хүүхдүүд гар угаахад хугацаа их зарцуулж, хичээлийн цаг сунгагдахаас гадна эрүүл ахуйн шаардлага хангахгүй байна.

Тиймээс аяга, тавгийг сургуулиас нэгдсэн байдлаар цэвэрлэн, олгох нь оновчтой боловч тогоочийн ажлын ачаалал нэмэгдэх үр дагавартай юм.

Харин Сайхан-Овоо сумын ерөнхий боловсролын сургууль шарах тоног төхөөрөмж ашиглан суралцагчдаас аягануудыг авч, нэгдсэн байдлаар ариутган цэвэрлэж өгч байгаа нь ариун цэвэр эрүүл ахуйн шаардлагыг хангаж, цаг хугацааны

хувьд давуу талыг бий болгож, үйлчилгээний ажилтны ажлын ачааллыг бууруулж байна.

Аймгийн хэмжээнд нийт 18 сургуулиас 12 сургууль тусгай хоолох заалтай боловч 6 сургууль зааланд, үлдсэн 12 сургууль ангидаа хооллож байна. Тусгай заалтай боловч ангидаа хооллож байгаа сургуулийн хувьд зориулалтын ширээ сандалгүй, олон хүүхэд зэрэг хүлээн авах хүчин чадал хүрэлцдэггүй, төсөв хөрөнгө дутмаг байдагтай холбоотой байна.

Тиймээс хооллох заалтай болох асуудлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах жагсаалтад оруулах, энэ тухай эцэг, эхчүүдэд ач холбогдлыг тайлбарлан таниулснаар иргэдийн саналаар дэмжигдэх боломжтой юм. Энэ талаар сумдын багийн иргэдийн Нийтийн Хуралд зөвлөмжөөр хүргүүлсэн.

Аудитаар эцэг, эхийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаар үдийн цай хөтөлбөр болон эрүүл хооллолтын талаарх ойлголт дутмаг болох нь харагдаж байв.

Хүүхдийн бие бялдрын болон оюун санааны өсөлт хөгжилтийг хангахад чанартай хоол тэжээл чухал бөгөөд үүнд эцэг эхийн оролцоо гол үүрэгтэй. Тиймээс эцэг, эхчүүд үдийн цай хөтөлбөр болон эрүүл хооллолтын талаарх мэдлэгтэй болсноор уг хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд түлхэц болох юм. Мөн үдийн цай хөтөлбөрийг цаашид хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь санал асуулгын дүнгээс харагдаж байна.

Сургуулийн зүгээс хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам, эрүүл хооллолт, түүний ач холбогдлын талаар эцэг, эх, хүүхэд, багш нарт сонирхолтой байдлаар сурталчлан таниулах, нэгдсэн ойлголттой болгох ажлыг тогтмол зохион байгуулахыг ерөнхий боловсролын сургуулиудад зөвлөмж хүргүүлсэн.

Зарим сургуулиуд шинэлэг санаа гаргаж, хүндрэлтэй асуудлуудыг өөрийн нөөц боломжийн хүрээнд оновчтой шийдсэн ч сургуулиудын уялдаа холбоо муутайгаас туршлагыг судалж нэвтрүүлэх ажил хийгдэхгүй байна.

Иймд үдийн цай хөтөлбөрийг оновчтой зохион байгуулан хэрэгжүүлж байгаа сургуулиудын туршлагыг бусад сургуулиудад нэвтрүүлэх талаар судлан, арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, соёлын газарт зөвлөсөн.


Тус аудитаар 10 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд 4 саналыг ҮАГ-аар дамжуулан хүргүүлээ.

## А УДИТЫН ТУХАЙ

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:** Аудитыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалгаар Үндэсний аудитын газрын харьяа Дундговь аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

**Аудитын зорилт:** Үдийн цай хөтөлбөрийн хүрээнд нөөцийг арвигч, хямгач бөгөөд үр ашигтай ашигласан эсэх, хөтөлбөрийн зорилго, зорилт биелэгдсэн эсэх, үйл ажиллагаа нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаа эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах дэд зорилтын хүрээнд асуудлыг авч үзсэн. Үүнд:



**Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:** Дараах хууль эрхийн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур, эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Эрүүл мэндийн тухай хууль;
- Ариун цэврийн тухай хууль;
- Хүнсний тухай хууль;
- УИХ-ын 2006 оны 47, 66 дугаар тогтоолууд,
- Засгийн газрын 2006 оны 194, 2012 оны 106 дугаар тогтоол;
- БСШУС-ын 2006 оны 08 дугаар сарын 23-ны 301 тоот тушаал, түүний 1, 2 дугаар хавсралтууд;
- БСШУС, ЭМС-ын 2006 оны 10 дугаар сарын 20-ны 379/341 дугаар хамтарсан тушаалаар ЕБС-ийн “Үдийн цай хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам;
- MNS 4946:2005 “Хоолны газрын ангилал, зэрэглэл. Ерөнхий шаардлага”;
- Бусад эрх зүйн актууд.

**Аудитын хамрах хүрээ:** Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллагын хөгжлийн санаачлагаас өгсөн арга зүйн дагуу сэдэв сонголтын шалгуур

үзүүлэлтүүд, онооны хүснэгт болон “Гүйцэтгэлийн аудитын журам”-ыг ашиглан “Үдийн цай” хөтөлбөрийг аудитын сэдвээр сонгосон.

Үдийн цай хөтөлбөрийн 2015, 2016 оны хэрэгжилтийг аймгийн төвийн “Эрдмийн далай” цогцолбор, “Говийн-Ирээдүй” цогцолбор, Хүмүүнлэг, Мандал сургуулиуд, Луус, Хулд, Дэлгэрхангай, Дэрэн, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдын нийт ерөнхий боловсролын 10 сургууль дээр ажиллаж, үдийн цай хөтөлбөрийн журам, төсөв хөрөнгийн төлөвлөгөө, тооцоо судалгаа, гүйцэтгэл, түүнд тавьсан мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт хийсэн танилцуулга, тайлан, дүгнэлт, сургуулийн хяналтын комиссын тайлан мэдээ, хурлын тэмдэглэл, болон холбогдох бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.

Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан, Өлзийт, Эрдэнэдалай, Адаацаг сумдын 8 сургуулийг судалгааны түвшинд аудитад хамруулсан.

**Аудитын арга зүй:** Аудитад Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим АДБОУС (300), Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Аудитын дээд байгууллагуудын олон улсын нийгэмлэгийн хөгжлийн санаачлагаас өгсөн арга зүй, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг мөрдөж дараах горим сорилыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Эцэг эхийн хяналтын зөвлөлийн гишүүд, Боловсрол, соёлын газрын бага боловсрол хариуцсан мэргэжилтэн, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч, сургуулийн захирал, эмч, нягтлан бодогч, нярав, тогооч болон бусад холбогдох хүмүүстэй онилсон бүлгийн хэлэлцүүлэг болон ярилцлага хийсэн;
- Аудитын явцад “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар эцэг эх, суралцагчид, багш нарыг хамруулан нийт 3348 хүнээс санал асуулга авч нэгтгэн, шинжилгээ хийж харьцуулалт хийв. Санал асуулгад эцэг эхийн 28 хувь, суралцагчдын 52 хувь, бага ангийн багш нарын 36 хувь тус тус хамрагдсан;
- Үдийн цай хөтөлбөртэй холбоотой олон улсын жишээг судалсан;
- Нөхцөл байдлын шинжилгээ, тулган баталгаажуулалт, зэрэгцүүлэлт, байдлуулалт зэрэг аудитын арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.
  - Үдийн цай хөтөлбөрт хамрагдах суралцагчдын төлөвлөсөн тоог ирцийн бүртгэлтэй харьцуулах, санхүүжилтийн тооцоолол, хэмнэлт хэтрэлтийн талаар дүн шинжилгээ хийх, нийлүүлэлтийн тооцоог бэлтгэн нийлүүлэгчтэй хийсэн гэрээтэй тулган шалгасан;
  - Аймгийн хэмжээний нийт ерөнхий боловсролын 18 сургуулиас 10 сургуульд Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг биечлэн үзэж, 2 сургуулийн суралцагчдад олгож буй хоолны шим тэжээлийг тодорхойлуулахаар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн шинжилгээ хийлгэв.

**Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа:** Аудитыг тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг хянан удирдаж, аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлын чанарын хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын багийн ахлах шинжээч Ч.Бэрхсайхан, шинжээч Д.Должинсүрэн нар 2016 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 2016 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийг дуустал гүйцэтгэлээ.

**Ерөнхий мэдээлэл:** “Тэтгэмж, мөнгөн тусламжийн хэмжээг тогтоох тухай” УИХ-ын 2006 оны 47 дугаар тогтоол, уг тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын 2006 оны 66 дугаар тогтоол, “Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 194 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, эрүүл мэндийн сайдын 2006 оны 379/341 дугаар хамтарсан тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд мөрдөх журмыг батлан, 2006 оны сүүлийн хагас жилээс эхлэн I-II анги, 2007 онд I-IV ангийн суралцагчдыг хамруулан, өдөрт үдийн цайны зардлыг 300 төгрөгт багтаахаар тогтоосон. Засгийн газрын 2008 оны 45 дугаар тогтоолоор хөтөлбөрт хамрагдах хүрээ болон үнэ өртгийг өөрчилж I-V ангийн суралцагчдад 400 төгрөг, 2012 оны 106 дугаар тогтоолоор 2013 оны эхнээс нэг суралцагчийн үдийн цайнд өдөрт 600 төгрөгийг зарцуулахаар тус тус өөрчлөлт оруулсан байна.

Дундговь аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 19 сургуулиас I-V ангийн суралцагчтай 18 сургуульд үдийн цайг хэрэгжүүлж байна. Аймгийн хэмжээнд 2015 онд 6 сургууль үдийн цайг үдийн хоол болгон, 10 сургууль 7 хоногийн 3 өдөрт нь үдийн хоол, бусад өдөрт гурилан бүтээгдэхүүн, 2 сургууль аймгийн хүнсний үйлдвэрийн гурилан бүтээгдэхүүнийг үдийн цайнд өгч байжээ.

Сургуулиудад үдийн цайны тогоочийн орон тоог нэмснээр 2016 оны байдлаар 13 сургууль үдийн цайг үдийн хоол болгон, хүүхдүүдэд өдөр бүр шинэ халуун хоол, аарц, буцалгаа, жүүс өгч, 5 сургууль өөрсдийн нөхцөл бололцоонд тулгуурлан 7 хоногийн 2-3 өдөрт нь халуун хоол өгснөөр, аймгийн хэмжээнд нийт сургуулийн 90 хувь нь үдийн цайг, үдийн хоол болгон хэрэгжүүлж байна.

Үдийн цай хөтөлбөрт 2015 онд 3681 суралцагч хамруулахаар төлөвлөж, 359,066.5 мянган төгрөгийн төсөв баталснаас, гүйцэтгэлээр 3998 суралцагч хамрагдаж, 334,435.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. 2016 онд 3998 суралцагчид хамруулахаар төлөвлөн, 400,837.0 мянган төгрөгийн төсөв баталж эхний хагас жилийн байдлаар 167,217.8 мянган төгрөг зарцуулжээ.

Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөл, шалтгаан, зорилго зорилтыг тодорхойлоогүй, гарах үр дүнг тооцох талаар эрх зүйн баримтад тусгаагүй нь уг хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөхөд хүндрэлтэй байлаа.



**Бүлэг 1**

Үдийн цай хөтөлбөрийн тооцоо, судалгааг үнэн зөв бодитой хийсэн байна

**1.1 Үдийн цай хөтөлбөрийн төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн байна.**

Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар тогтоолоор нэг хүүхдийн үдийн цайны өдрийн зардлыг 600 төгрөгөөр тогтоосны дагуу 2015 онд гүйцэтгэлээр 3,801 хүүхдэд 318,216.1 мянган төгрөг, 2016 онд 4,117 хүүхдийг хамруулан 3 дугаар улирлын байдлаар 215,753.7 мянган төгрөгийг үдийн цайнд зарцуулжээ.

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 18 сургуулийн үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулах 2016 оны төсөв 401,837.0 мянган төгрөгөөр батлагдсанаас, Гурвансайхан сумын сургуулийн төсвийг 1,000.0 мянган төгрөгөөр бууруулж, 400,837.0 мянган төгрөг болгон тодотгон баталсан байна.


Дээрх 18 сургуулиас суралцагчдын тоог урьдчилан тооцоолдог эсэх талаар судалгаа авахад бүх сургууль суралцагчдын тооны прогноз хийдэг байна.

Аудитад хамрагдсан сургуулиудын үдийн цай бэлтгэх үйл ажиллагаа, хүүхдүүдийн хооллох нөхцөл байдалтай танилцан ажиглалт хийхэд, тогооч тухайн өдөр хичээлдээ ирсэн хүүхдийн тоогоор бус ирвэл зохих хүүхдийн тоогоор хоолыг бэлтгэж байна. Тухайлбал:

Хүснэгт 1

Сургуулийн нэр	Тулгалт хийсэн хоног	Зөрүү гарсан хүүхдийн тоо
Сайхан-Овоо	9	18
Дэлгэрхангай	14	126
Луус	10	14

Үдийн цай олголтыг хүүхдийн ирцтэй түүвэрлэн тулгалт хийхэд Сайхан-Овоо суманд 9 хоногт 18 хүүхдийн, Дэлгэрхангай суманд 14 хоногт 126 хүүхдийн, Луус сумын сургуульд 10 хоногт 14 хүүхдийн хоол илүү бэлтгэсэн байв. (Хүснэгт 1) Энэ нь хөдөө орон



нутагт нийтээр амрах баярын өдөр болон хичээлийн жилийн улирлын амралт эхлэх, дуусах хугацаа 7 хоногийн дундуур таарах үед хүүхдийн ирц буурдагтай холбоотой байна.

Энэ талаар холбогдох хүмүүсээс тодруулахад “Тухайн өдөр хэдэн хүүхэд ирэхийг урьдчилан мэдэх боломжгүй, хичээл

эхлээд ирц авсны дараа хоол бэлтгэхэд хугацаандаа амждаггүй.” гэсэн тайлбар өгч байна. Тогоочийн ажлын ачаалал аймгийн төв болон суманд харилцан адилгүй байгаа бөгөөд тус судалгааг хүснэгт 5-аас харах боломжтой.

*Сайн туршлага:*

*Эрдэнэдалай сумын сургууль нэг ээлжинд дунджаар 398 суралцагч үдийн цайнд ордог бөгөөд үдийн цайны 2 тогоочтой тул тухайн өдрийн хүүхдийн ирцийн тоонд үндэслэн хоол бэлтгэж амждаг байна.*

Сургуулиуд хүүхдийн ирцийн тоонд үндэслэн хоол бэлтгэх нь хөтөлбөрийн зардал бодитой тооцогдох учраас олон хүүхэдтэй сургуульд туслах тогооч ажиллах зайлшгүй шаардлага гарч байна. Иймд энэ асуудлыг судалж, шийдвэрлэх талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд санал хүргүүлээ.

Хэдийгээр хоолыг хүүхдийн ирцийн бүртгэлээс зөрүүтэй хийж байгаа ч илүү гарсан хоолыг ангиудад хуваарилан, хүүхдүүдэд нэмж өгснөөр хоолны үлдэгдэл гардаггүй байна. Энэ нь суралцагчдад өгч байгаа хоолны хэмжээ бага, нэмэгдүүлэх шаардлага байгааг харуулж байна.

*Олон улсын жишээ:*

*АНУ*

*Үдийн цайны зардлыг өрхийн орлогоос хамааруулан төрөөс эсвэл тухайн суралцагч өөрөө хариуцах эсэх нь ялгаатай байдаг. Үүнд:*

- Холбооны ядуурлын түвшний 130 хувь ба түүнээс доош орлоготой өрхийн хүүхдүүд сургуулийн хоолыг үнэ төлбөргүй авах эрхтэй.*
- Холбооны ядуурлын түвшний 130-185 хувьд хамаарагддаг орлоготой өрхийн хүүхдүүд хөнгөлөлттэй үнээр хоол авдаг ба өглөөний цайнд 30 центээс илүү зардал төлдөггүй.*
- Холбооны ядуурлын түвшний 185 хувиас дээш орлоготой өрхийн хүүхдүүд хоолны мөнгөө өөрсдөө төлдөг.*

*2014-2015 оны хичээлийн жилд нэг суралцагчид ногдох төр хариуцах өглөөний цайнд 1.62 доллар, хөнгөлөлттэй үнэтэй өглөөний цайнд 1.32 доллар, өөрөө төлөх хоолны зардалд 0.28 долларын зардал гарсан байна.*

*Их британи:*

*Төрөөс тэтгэвэр болон янз бүрийн хөнгөлөлт тусламж авдаг гэр бүлийн хүүхэд сургуулийн өдрийн хоолыг үнэгүй авах эрхтэй байдаг.*

Аймгийн хэмжээнд үдийн цайнд хамрагдаж байгаа нийт 4117 суралцагчийн 3270 суралцагч нь амьжиргааны түвшнээс дээгүүр ба дундаж түвшний орлоготой өрхөд, 838 нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхөд хамаарч байна.(Хавсралт №1)

Манай орны хувьд өрхийн амьжиргааны түвшинд үндэслэн үдийн цайны зардлыг ялгаатай байдлаар эцэг, эхээс гаргуулах боломжийг судалж шийдвэрлэх нь улсын эдийн засгийн өнөөгийн байдалд нэмэр болох төдийгүй хүүхдүүдийн үдийн цайны хэмжээ, түүнээс олж авах шим тэжээлийг нэмэгдүүлж болох бөгөөд, хяналт сайжрах талтай.

Энэ асуудлыг судлах талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд уламжлагаар ҮАГ-т санал хүргүүлээ.

**1.2 Үдийн цай хөтөлбөрийн гүйцэтгэлийг бодитой тооцож тайлагнасан байна.**

Сайнцагаан сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль, Хулд сумын сургууль нь үдийн цайг гэрээт нийлүүлэгчээр гүйцэтгүүлж, бусад сургууль орон тооны тогооч ажиллуулан өөрсдөө үдийн цайг бэлтгэж байна.

Аудитад хамрагдсан 10 сургуулийн үдийн цайнд олгосон хоолны материалын үнийг сургууль тус бүрийн худалдан авсан үнэ болон аймгийн төвийн 4 дэлгүүрийн үнэтэй харьцуулалт хийхэд үнийн зөрүү бага, зах зээлийн дундаж үнэ ханштай ойролцоо байна. (дэлгэрэнгүй судалгааг хавсралт №2-т)

Хэдийгээр сургуулиудын худалдан авсан хүнсний материалын үнэ зах зээлийн дундаж үнэтэй ойролцоо байгаа ч үдийн цай бэлтгэх ажлыг гэрээт нийлүүлэгчээр гүйцэтгүүлдэг сургуулиудын хувьд нийлүүлэгчийн ашиг нэмэгдэж үдийн цайны төсөвт багтаахын тулд нэг хүүхдэд оногдох хоолны хэмжээ буурах, төсвийн хөрөнгийг арвилан



хэмнэлтгүй зарцуулах сөрөг үр дагавар ажиглагдаж байна. Тухайлбал: Хулд сумын сургуулийн 5 өдрийн хоолны өртгийг тооцож, шилжүүлсэн мөнгөн дүнтэй харьцуулахад дунджаар нэг өдөрт 26.0 мянган төгрөгийг хэмнэх боломжтой байжээ. (Хүснэгт 2)

Хүснэгт 2 /төгрөгөөр/

	Хоолны нэр	Нэг хүүхдэд ногдох өртөг	Хүүхдийн тоо	Нийт өртөг	Шилжүүлсэн мөнгө	Зөрүү
1	Зуган шөл	357.7	139	49,720.30	83,400.00	33,679.70
2	Кимбаб, сүүтэй цай	516.7	126	65,100.40	83,400.00	18,299.60
3	Үзэмний шүүс, еэвэн	469.4	124	58,199.40	83,400.00	25,200.60
4	Бууз, сүүтэй цай	478.8	132	63,200.30	83,400.00	20,199.70
5	Үзэмтэй будаа	383.0	138	52,849.90	83,400.00	30,550.10
				<b>289,070.30</b>	<b>417,000.00</b>	<b>127,929.70</b>

Дээрх судалгаанаас 5 өдрийн нийт хоолны бодит өртөг 289.1 мянган төгрөг болсон ч гэрээний үнийн /1 хүүхэд өдөрт 600 төгрөг/ дагуу 417.0 мянган төгрөг шилжүүлснээр 127.9 мянган төгрөг нь тухайн нийлүүлэгчийн ашиг болж байна. Бусад сургуулиудын жишгээр орон тооны тогооч авч ажиллуулбал тогоочийн цалинг сургуулийн төсвөөс олгож, үдийн цайны хэмнэсэн төсвөөр илүү чанартай, орц ихтэй хоол хүнс нийлүүлэх боломж байна.

Эдгээр сургуулиудын үдийн цай нийлүүлэх гэрээний дүн нь хоолны өртгөөс үл хамааран нэг хүүхдэд тогтмол 600 төгрөг байна.

Тиймээс Хулд сумын сургууль, Сайнцагаан сумын 3-р сургуулиуд орон тооны тогооч ажиллуулж, үдийн цайг өөрсдөө бэлтгэж байх боломжийг судлах хэрэгтэй.

Аудитын явцад 10 сургуулийн агуулахын бүртгэл, ордерыг бараа материалын тайлантай тулгаж, үлдэгдэлд хяналтын тооллого хийхэд Сайнцагаан сумын 2-р сургуульд 366.7 мянган төгрөгийн мах дутсан зөрчил илэрч, нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо. Бусад сургуулиудын хувьд зөрүү гараагүй болно.

Мөн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдэлтийг түүвэрлэн шалгахад Сайнцагаан сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуульд дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- ✓ 2016 оны 5 сарын 17-20, 31-ний өдрүүдийн хүүхдийн ирцийн бүртгэл байхгүй, 2016 оны 06 сарын 3-ны өдрийн 104.1 мянган төгрөгийн хоолны ордер, баримтгүй,
- ✓ Багшийн журналтай үдийн цайнд орсон хүүхдийн ирцийн бүртгэлийг тулгаж үзэхэд сарын сүүлийн өдрүүд болон хүүхдийн амралтын өдрүүдэд хүүхдийн тоог нэмэгдүүлж бүртгэн, бодит ирцээс 148 хүүхдийг илүү бүртгэсэн.

Эдгээр зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах талаар хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

## Бүлэг 2

Үдийн цай хөтөлбөрийн хооллох орчин бүрдээгүй байна.

**2.1 Хоол бэлтгэж буй газар болон хооллох орчин стандарт, эрүүл ахуйн шаардлага хангаагүй байна.**

### Хоол бэлтгэж буй газрын талаар

Сайхан-Овоо, Луус сумдын сургууль зориулалтын гал тогоогүй, бусад 16 сургууль зориулалтын гал тогоотой бөгөөд мэргэжлийн байгууллагаас ашиглах боломжтой гэж дүгнэжээ.

Гал тогоотой сургуулиудын хувьд шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан эсэх талаар судалгаа авахад нийт сургуулийн 66.6 хувь буюу 12 сургууль бүрэн хангагдсан, 33.4 хувь буюу 6 сургууль бүрэн хангагдаагүй байна.

Сургуулиудын хүүхдийн тоо, хэдэн ээлжээр хичээллэдгээс хамааран, багш, тогооч, үйлчилгээний ажилтнуудын ажлын ачаалал, шаардлагатай тоног төхөөрөмж, сандал ширээний хүртээмж, зориулалтын байр, хангамжийн асуудал ялгаатай байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3  
/2016-2017 оны хичээлийн жилийн байдлаар/

1 ээлжинд ногдох суралцагчийн тоо	Өглөөний ээлж			Өдрийн ээлж			2 ээлжинд нийт		
	Сургууль	Бүлэг	Суралцагч	Сургууль	Бүлэг	Суралцагч	Сургууль	Бүлэг	Суралцагч
100 хүртэл	7	31	543	4	13	211	7	44	754
101-300	7	42	942	3	17	495	7	59	1437
301-500	4	53	1618	1	9	308	4	62	1926
<b>Нийт</b>	<b>18</b>	<b>126</b>	<b>3103</b>	<b>8</b>	<b>39</b>	<b>1014</b>	<b>18</b>	<b>165</b>	<b>4117</b>

Дундговь аймагт үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлдэг 18 сургуульд 2016-2017 оны хичээлийн жилд 4117 суралцагч суралцаж байна. Эдгээр сургуулиас үдийн цайнд хамгийн багадаа нэг ээлжинд 28 хүүхэд /Цагаандэлгэр сум/, хамгийн их нь 483 /ГИЦС/ суралцагч хамрагдаж байна. Энэ байдлаас сургуулиудын үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам нь янз бүр байх талтай учир асуудлыг олон талаас харж, шинжлэх хэрэгцээ гарч байна.

Үдийн цай хөтөлбөрт хамрагдаж байгаа нийт суралцагчид, бүлгийн тоонд үндэслэн нэг багшид ногдох суралцагчийн тоог гаргахад сургуулиудын ачаалал нэлээд ялгаатай байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4  
2016-2017 оны хичээлийн жилийн байдлаар

№	Үдийн цай хөтөлбөр хэрэгждэг сургуулиуд	Бүлгийн тоо	Хүүхдийн тоо	Үүнээс				Нэг багшид ногдох суралцагч /дундаж/	Нэг ээлжинд ногдох суралцагч /дундаж/	Ээлжийн тоо
				Өглөө		Өдөр				
1	Цагаандэлгэр	5	53	2	28	3	25	11	28	2
2	Дэлгэрцогт	5	73	5	73			15	73	1
3	Өлзийт	5	75	5	75			15	75	1
4	Баянжаргалан	5	93	5	93			19	93	1
5	Луус	5	99	5	99			20	99	1
6	Говь-Угтаал	5	111	5	111			22	111	1
7	Өндөршил	5	122	5	122			24	122	1
8	Дэрэн	7	142	4	83	3	59	20	83	2
9	Хулд	8	145	8	145			18	145	1
10	Гурвансайхан	8	150	6	115	2	35	19	115	2
11	Сайхан-овоо	6	161	6	161			27	161	1
12	Адаацаг	10	184	5	92	5	92	18	92	2
13	Дэлгэрхангай	10	235	6	126	4	109	24	126	2
14	3-р сургууль	11	330	6	162	5	167	30	167	2
15	Мандал сургууль	15	440	15	440			29	440	1
16	ГИЦС	18	483	18	483			27	483	1
17	Эрдэнэдалай	18	608	10	389	8	219	34	398	2
18	ЭДЦС	19	613	10	306	9	308	32	308	2
Нийт дүн		165	4117	126	3103	39	1014	22.4	173.3	
Сумын төв. дундаж		7	161	6	122	4	90	20	123	
Аймгийн төв. дундаж		16	467	12	348	7	238	30	350	


Багш өдөр бүр дунджаар:  
Аймгийн төвд 30  
Сумын төвд 20  
хүүхэдтэй ажиппалаг.

Хөдөө сумын сургуулиудын ачаалал аймгийн төвийн сургуулиудын ачааллаас 2 дахин бага байна. Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол үүргийг багш гүйцэтгэдэг. Тухайлбал: хүүхдүүдийг хоолны өмнө гарыг нь угаалгах, аяганы ариун цэврийг хангуулах, хүүхдүүдэд хоол аягалж өгөх, хоол идсэний дараа хичээллэх орчинг бүрдүүлнэ. Зарим сургуулийн эцэг, эхийн төлөөлөл багшийн ажилд туслах зорилгоор ээлжээр оролцдог байна.



**Сайн туршлага:**

Дэлгэрхангай сумын сургуульд суралцагчид бусад ангийн суралцагчдын ариун цэврийн байдалд хяналт тавьж, тэмдэглэл хөтөлдөг. Өөр хоорондоо хяналт тавьснаар хүүхдүүд илүү хариуцлагатай болж ариун цэврийг сайн сахиж байна.




Санал асуулгад хамрагдсан нийт багш нарын болон 1-р ангийн багш нарын 72 хувь нь үдийн цайны үргэлжлэх хугацааг хангалттай гэж үнэлжээ.

Үдийн цай тараах, хооллох орчны эрүүл ахуйг хангах ажилд эцэг, эх болон суралцагчдын оролцоог нэмэгдүүлж, багшийн ажлын ачааллыг бууруулах боломж байна.

**Хооллох орчны талаар**


Аймгийн хэмжээнд нийт 18 сургуулиас 12 сургууль тусгай хооллох заалтай боловч 6 сургууль зааланд, үлдсэн 12 сургууль ангидаа хооллож байна. Тусгай заалтай боловч ангидаа хооллож байгаа сургуулийн хувьд зориулалтын ширээ сандалгүй, олон хүүхэд зэрэг хүлээн авах хүчин чадал хүрэлцээгүйтэй холбоотой байна.



Судалгаанд оролцогч багш нарыг анги даалтын байдлаар нь ангилж, жигд түүвэрлэсэн.

Нийт 61 багш санал асуулгад оролцсон бөгөөд багш нарын 60 хувь нь хооллох орчны ариун цэвэр эрүүл ахуйд “Сайн” гэсэн үнэлгээ өгч, 1-р ангийн багш нарын 36 хувь нь сайн, 63 хувь нь “Дунд” гэсэн үнэлгээ өгчээ.

Асуулгад хамрагдсан нийт 1148 эцэг эхийн 722 нь буюу 63 хувь нь сургуулийн хооллох орчин, эрүүл ахуйг “Сайн” гэж үнэлсэнээс:



- Сумын 58.3 хувь  
- Аймагийн төвийн 66.7 хувь

Үлдсэн 37 хувь нь “Дунд”, “Муу” гэж үнэлжээ.

Санал асуулгын дүнгээс харахад эцэг эх, багш нарын хариулт харилцан адилгүй байгаа ч бодит байдал дээр орчин хангагдаагүй байна.

Өнөөгийн байдлаар сургуулиудад шаардлагатай

тоног төхөөрөмж, орон байрны хүчин чадал, орчны эрүүл ахуй, ажиллах хүч бүрэн хангагдаагүй нь үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багагүй бэрхшээл, хүндрэл гарч байна. Иймд төрөөс сургуулиудыг зориулалтын гал тогоотой болгох, гал тогооны хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөл хийх зэргээр үдийн цай өгөх боломжийг бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай боловч төсөв, хөрөнгийн хувьд уг асуудлыг шийдэх бололцоо муу байна.

Аудитын явцад хийсэн бүлгийн ярилцлагад ангидаа үдийн цай уух нь тохиромжгүй, зориулалтын зааланд хооллох нь зүйтэй гэсэн саналыг эцэг, эхийн төлөөлөл хэлж байсан. Тиймээс хооллох заалтай болох асуудлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах жагсаалтад оруулах, энэ тухай эцэг, эхчүүдэд ач холбогдлыг тайлбарлан таниулснаар иргэдийн саналаар дэмжигдэх боломжтой юм. Энэ талаар сумдын багийн иргэдийн Нийтийн Хуралд зөвлөмж хүргүүлээ.

Эрдэнэдалай сумын сургууль Тайландын эрхэмсэг гүнжийн ивээл дор хэрэгжих “Хөдөө аж ахуйд суурилсан сургуулийн үдийн хоол” төслийн хөрөнгө оруулалтаар зориулалтын заал, туслах аж ахуй, цэвэр, бохир усны шугам, хүлэмжийг цогцоор нь шийдвэрлэх ажлын эхлэл тавигдсан байна. Тус үйл ажиллагаа 2017 оноос хэрэгжиж эхлэх бөгөөд нийт төсөв нь 177,268.5 мянган төгрөг байна.




Нийт 18 сургуулиас 6 сургууль цэвэр бохир усны төвлөрсөн шугамд холбогдсон, 4 сургууль өөрсдийн эх үүсвэрийг ашиглан сургуулийг усаар хангаж, 8 сургууль зөөврийн ус ашиглаж байна.

Сумдын сургуулиуд төвлөрсөн цэвэр, бохир усанд холбогдоогүй, мөн угаалтуурын тоо хүрэлцээгүйгээс хүүхдүүд гар угаахад хугацаа их зарцуулж хичээлийн цаг сунгагдахаас гадна эрүүл ахуйн шаардлага хангахгүй байна.

Аймагийн төвийн сургуулиудад угаалтуурын тоо дутагдалтай байгаа нь багш, эцэг, эх, суралцагчдаас авсан санал асуулгын дүнгээс харагдаж байна.






Нийт суралцагчдын 58 хувь буюу 2751 суралцагчаас асуулга боловсруулж, судалгаа авахад 41 хувь нь буюу 1118 суралцагч сальфеткаар гараа цэвэрлэдэг ба эдгээрийн 1025 нь аймгийн төвийн сургуульд суралцдаг байна.

Харин угаалтуурт угаадаг суралцагчийн тоо 989 буюу 36 хувь байна. Сум, аймгийн төвд угаалтуурын хэрэглээ ойролцоо гарч байгаа нь аймгийн төвд төвлөрсөн системд холбогдсон газарт угаалтуурын тоо хүрэлцээ муутай байгааг харуулж байна.

Харин угаалтуурт угаадаг суралцагчийн тоо 989 буюу 36



Мөн гараа цэвэрлэдэггүй хүүхдийн тоо 32 буюу 1 хувь, үүнээс 24 хүүхэд аймгийн төвийн сургуульд суралцаж байна. Энэ нь сальфетка, бусад цэвэрлэх хэрэгсэл худалдан авах чадваргүй, угаалтуур хүрэлцээгүй зэрэгтэй холбоотой байна.

**Сайн туршлага:**


**Сайхан-Овоо сум:**

Хүүхдийн гар угаах асуудлыг оновчтой шийдвэрлэсэн байна. Тухайлбал: хүүхдүүдийн гарын алчуурыг тусгай төхөөрөмжөөр ариутган халааж ашиглаж байгаа нь ажилчдын ажлын ачааллыг бууруулж, цаг хэмнэхээс гадна нян, бохирдлыг арилгах сайн арга юм. Тухайн тоног төхөөрөмжийн үнэ 120.0 мянган төгрөг байна.



Асуулгад 59 багш, 2 сургалтын менежер оролцсон.

Оролцогчдын 77 хувь нь хүүхдийн гар угаалт, ариун цэврийн байдалд сайн үнэлгээ өгсөн бол 61 хувь нь аяга халбаганы ариун цэвэр “Сайн” гэж үнэлжээ.



Аяга халбаганы ариун цэврийн байдлыг 826 эцэг, эхчүүд буюу 71.9 хувь нь “Сайн” гэсэн үнэлгээ өгчээ. Үүний 65.1 хувь нь аймгийн төвд 34.9 хувь нь сумых байна.



Аяга халбаганы ариун цэврийн байдалд багшаас өгсөн үнэлгээ харьцангуй жигд байна.

Нийт багш нар болон 1-р ангийн багш нарын 63 хувь

нь “Сайн” гэж үнэлжээ.

Аяга, тавгийг гэрээс нь авчруулахаар зохион байгуулсан сургуулиудын үдийн цай олголтод ажиглалт хийхэд зарим хүүхдүүд аягаа мартаж, аяга, тавгаа цүнхэлж явдаг ч угаадаггүй, угаасан ч хангалтгүй, өдөр бүр аяга зөөх нь хүндрэлтэй байдал харагдаж байлаа. Сургуулиас нэгдсэн аяга тавгаар хангавал ариутгалын асуудал, тогоочийн ажлын ачаалал нэмэгдэх үр дагавартай. Ялангуяа цэвэр усны нэгдсэн системд холбогдоогүй сумдын сургуулиудын цайны газруудад аяга тавгаа 3 дамжлагаар угаадаг ч бага хэмжээний ус хэрэглэж байгаа нь тос, бохирдолт, ариутгалын бодисыг бүрэн цэвэрлэхгүйгээс шаардлага хангахгүй байна

**Сайн туршлага:**

Сайхан-Овоо сумын сургууль суралцагчдаас аягануудыг авч, аяга ариутгаж, шарах тоног төхөөрөмж ашиглан нэгдсэн байдлаар сургуулиас ариутган цэвэрлэж өгдөг. Энэ нь ариун цэвэр эрүүл ахуйн шаардлагыг хангаж, цаг хугацааны хувьд давуу талыг бий болгож байна. Тоног төхөөрөмжийн үнэ 345.0 мянган төгрөг байна.

Үдийн цай хөтөлбөрийг оновчтой зохион байгуулж хэрэгжүүлж байгаа сургуулиудын туршлагыг бусад сургуулиудад нэвтрүүлэх талаар судлан арга хэмжээ авахыг Боловсрол, соёлын газарт зөвлөлөө.

## 2.2 Хүнсний бүтээгдэхүүн стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

Сургуулиудад хоол, хүнсний бүтээгдэхүүнээс дээж авч бүртгэл хөтлөх ажил сайн хийгддэг бөгөөд сургуулиуд бүтээгдэхүүнд итгэмжлэгдсэн шинжилгээний байгууллагаар дүгнэлт гаргуулсан байна.

Аймгийн төвийн сургуулиуд талх, нарийн боов, бэлэн бүтээгдэхүүнээ өдөр бүр татаж, хүнсний ногоог 1-7 хоногоор, махыг 7-14 хоногоор татан авч байна.

Сумдын сургуулиудын хувьд мах, сүү, цагаан идээнээс бусад бүтээгдэхүүний татан авалтыг богино хугацаагаар хийж чадахгүй байна. Энэ нь тухайн сумын алслагдсан байдал, суманд үйлдвэрлэгч байхгүйтэй холбоотой юм. Суманд үйл ажиллагаа явуулж буй компани, дэлгүүрээр дамжуулж хүнсний материал, бүтээгдэхүүнээ татаж байгаа нь хугацааны хувьд хоцрогдолтой, бүтээгдэхүүний хадгалалтын горим алдагдах эрсдэлтэй төдийгүй тухайн компани тээврийн зардал, өөрийн ашгаа нэмснээр үнийн хувьд харьцангуй өндөр болдог.

### АНУ

Сургуулийн өдрийн хоолны үйлчилгээнд дотоодын түүхий эд, бүтээгдэхүүн хэрэглэхийг хуулинд тусгасан.

Манай орны хувьд хуульд тусгагдаагүй ч орон нутагт жижиг дунд үйлдвэрийг дэмжих бодлогын хүрээнд сүү, сүүн бүтээгдэхүүн, суманд үйлдвэрлэх боломжтой хүнсний бүтээгдэхүүний талаар судалж, сум хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний чиглэлд оруулан тухайн үйлдвэрлэлийг эрхлэх сонирхолтой этгээдийг дэмжиж үдийн цай хөтөлбөртэй уялдуулах, мөн сумдын бусад байгууллагын хүнсний материалыг хангаж ажиллах боломжийг судлах хэрэгтэй байна.

Энэ талаар сургуулийн захирал, нягтлан бодогч, нярав нартай ярилцлага хийхэд “Мах, сүү, цагаан идээг иргэдээс худалдан авах нь илүү үр дүнтэй боловч ТБОНӨХБАҮХАТ хуульд зааснаар хувь хүнтэй гэрээ байгуулах боломжгүй байдаг” гэсэн тайлбар өгч байсан. Энэ асуудлыг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар шийдвэрлэх боломжтой эсэхийг тодруулахад энэ талаар тодорхой ойлголтгүй байлаа.

Орон нутагт малчид, хүнс ногоо тариалагч жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг хувь хүмүүсийг сум хөгжлийн сангаас дэмжлэг үзүүлж бүлэг байгуулах ажлыг зохион байгуулах, тендер шалгаруулалтыг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах боломж байна.

Аудитын явцад үдийн цайны чанартай холбоотой өргөдөл, гомдол ирсэн эсэх талаар судалж үзэхэд 2015 онд Сайнцагаан сумын Мандал сургуульд хоолны хордлого гарснаас, өөр санал, гомдол гараагүй байна. Тус сургуульд хоолны хордлого гарсан шалтгааныг Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчаас

тодруулахад “Тогооч тухайн өдрийн хоол хийхдээ өмнөх орой нь чанаж хоносон гоймонтойгоо холин хуурга хийж өгснөөс үүдэлтэй” гэсэн тайлбар өгөв. Мөн шалгалт хийхээр очиход, өмнөх өдрийн хоолны дээжийг 48-72 цагийн дараа устгах байтал 24 цаг болгоод устгасан учир хоолонд шинжилгээ хийх боломжгүй байжээ. Энэ зөрчилд дараах арга хэмжээг авсан байна. Үүнд:

- Улсын байцаагчийн актаар гал тогоог хааж, зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн.
- Сургуулийн захирлыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлэн торгосон.
- Тогооч, эмчийг нь ажлаас халах сахилгын арга хэмжээ авч, 3 хүнд захиргааны арга хэмжээ авсан байна.


Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2015-2016 онд 10 сургуулийн хоолноос дээж аван шинжилгээ хийж, шим тэжээлийн хэмжээг тодорхойлжээ. Шинжилгээний дүгнэлтээр эдгээр сургуулиуд бүгд журамд заасан 340 килокалороос дээш байсан бөгөөд дундаж илчлэг нь 553.9 килокалор гарсан байна. (Хавсралт 3)

Аудитын явцад аймгийн төвийн 2 сургуулийн үдийн цайнд өгч байгаа хоолноос шим тэжээлийн шинжилгээ хийхэд 340 килокалор байхаас ЭДЦС 256.0 кило калор, 3-р сургууль 313.3 килокалорын илчлэгтэй гэсэн дүгнэлт гарсан байна. Энэ нь сургуулиуд шим тэжээлийн үзүүлэлтийг тогтмол хангаж чадахгүй байгааг илтгэж байна. Тиймээс сургуулийн эмч, хяналтын комисс, эцэг, эхчүүд үдийн цайгаар олгож буй хоолны орц, нормыг хянаж, илчлэгийн хэмжээг тогтмол хангаж ажиллах шаардлагатай.

*Олон улсын жишээ:*

*Баруун Австрали:*

*Амьжиргааны түвшин доогуур өрхийн хүүхдүүд амралтын өдрүүдэд гэртээ идэж буй хоолноос хангалттай хэмжээний илчлэгийг авч чаддаггүй тул даваа болон баасан гаригт өндөр илчлэг бүхий хоолыг суралцагчдын үдийн хоолонд өгдөг.*



Үдийн цайны амт чанар, тэжээллэг байдлыг асуулгад хамрагдсан 1148 эцэг эхийн 739 нь буюу 64.3 хувь нь “Сайн” гэсэн бол 35.7 хувь нь “Дунд” гэж хариулснаас харахад сэтгэл ханамжгүй байдал тодорхой хувийг эзэлж байна.

Аудитаар 10 сургуульд үдийн цайгаар олгож байгаа хүнсний зүйлийн төрлийн эзлэх хувийг тогтоох зорилгоор харьцуулалт хийлээ.

Сургуулиудад дараалсан 20 хоногийн хоолны цэсийг сонгон түүвэрлэхэд эдгээр хоногуудад үдийн цайгаар ихэвчлэн хоол өгсөн, харин сүү, цагаан идээ, жимс, жимсгэнийн эзлэх хувь харьцангуй бага бөгөөд аймгийн төвийн сургуулиуд сумдын сургуулиас энэ төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг түлхүү өгсөн нь харагдаж байна. Тухайлбал:

№	Сургуулийн нэрс	Хоол	Сүү цагаан идээ	Жимс, жимсгэний шүүс	Боов, талх
1	ЭДЦС	12	12	0	8
2	ГИЦС	10	12	10	20
3	Сайнцагаан 3-р сургууль	13	5	6	10
4	Мандал сургууль	7	10	3	20
5	Дэрэн	10	5	10	10
6	Дэлгэрцогт	16	5	0	5
7	Сайхан-овоо	9	8	9	4
8	Дэлгэрхангай	14	3	5	5
9	Луус	12	8	4	2
10	Хулд	12	0	4	8
<b>Нийт</b>		115	68	51	92
<b>57.5</b>	34		25.5	46	

Сонгосон 20 хоногт ЭДЦС, ГИЦС, Мандал, Сайхан-Овоо, Луус сумын сургуулиуд цагаан идээг 8-аас дээш хоногт өгч байхад, ГИЦС, Дэрэн, Сайхан-Овоо сумын сургуулиуд жимс, жимсгэнийг 9-өөс дээш өдрүүдэд өгсөн байна.

Онилсон бүлгийн ярилцлагаар эцэг эхийн төлөөлөл хүүхдүүдэд еэвэн өгөхөд, идэж чадахгүй цүнхэнд хийснээр, хог болон хувирдаг тул зохимжгүй

гэсэн санал гарсан. Иймд талх, нарийн боовны хувьд сонголтод анхаарах шаардлагатай.

Суралцагчдаас авсан санал асуулгаар үдийн цайгаар өгч байгаа хоол, цай таалагддаг уу? гэсэн асуултад нийт хүүхдүүдийн 96 хувь нь “Таалагддаг” гэж хариулсан.

Ямар төрлийн хоол, хүнс голдуу өгдөг талаар суралцагчдаас авсан санал асуулгын дүнгээр 40 хувь нь “хоол” гэж хариулсан. Үүнээс аймгийн төв- 24 хувь, сум 16 хувь байна. Талх, нарийн боов 30 хувийг эзэлж байгаагаас аймгийн төв- 22 хувь, сум- 8 хувь байна.



Харьцуулсан судалгаагаар хүүхдүүдийн голчлон хэрэглэж буй хүнс, эрүүл мэндэд сайн гэж боддог хүнсний зүйлээс зөрүүтэй байгааг диаграммаас харж болно.

*Сайн туршлага:*

*Сайхан-Овоо сумын сургууль олон төрлийн хоол, хүнсний бүтээгдэхүүнийг үдийн цайнд өгдөг бөгөөд бүтээгдэхүүнийг жигд хуваарилдаг. Суманд үйлдвэрлэсэн сүү, чацарганыг хоол хүнсэндээ түлхүү хэрэглэж байгаа нь орон нутгийн үйлдвэрлэгчдээс хямд үнээр худалдан авах боломж бүрдсэн байна.*

*Сайнцагаан сумын ГИЦС өдөрт нэг ээлжинд 2 удаа хоол, цай өгдөг. Өглөөний цайнд талх, боов, сүү, жимсний шүүс зэрэг хөнгөн чанарын зүйл, үдийн цайнд хоол, цай өгч байгаа нь хүүхдүүдийн эрүүл мэндэд сайн талтай байна.*

Сургуулиуд ГИЦС-ийн туршлагыг судалж, хэрэгжүүлэх боломжийг хайх нь зүйтэй.

*Олон улсын жишээ:*

Баруун Австрали:

1. Сургуулийн туслах аж ахуйгаас өндөг, хүнсний ногоо, жимс жимсгэнэ нийлүүлдэг.

Аймгийн хэмжээнд 5 сургууль туслах аж ахуй эрхэлдэг бөгөөд 4 сургууль нь мал аж ахуйтай боловч малын тоо цөөхөн учир үдийн цайнд бүтээгдэхүүн нийлүүлдэггүй. Харин ГИЦС чацарганы талбайтай болж, ургацаа хураан үдийн цайнд нийлүүлэх төлөвлөгөөтэй байна. Туслах аж ахуйгаас хүнсний материал бэлтгэх нь зах зээлийн үнээс хямд, найдвартай, аюулгүй, эрүүл хүнсээр хүүхдүүдийг хангах боломж бүрдэх юм.

Тиймээс сургуулиуд туслах аж ахуйд түшиглэн, үдийн цай бэлтгэх боломжийг судлах хэрэгтэй.

**Бүлэг 3.**


*Үдийн цайг үдийн хоол болгон хэрэгжүүлсэн нь оновчтой шийдэл боловч эрх зүйн орчин бүрдээгүй байна.*

**3.1 Үдийн цай хөтөлбөрийг цаашид сайжруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.**

Багш, сургалтын менежер, эцэг эхийн төлөөлөлтэй хийсэн онилсон бүлгийн хэлэлцүүлэгээр “үдийн цай өгснөөр хүүхдүүд ядарч өлсөх нь багасч, хичээлдээ идэвхтэй оролцож, сурлагын дүн сайжирч байгаа” гэсэн санал гарсан ч аймгийн хэмжээнд сурлагын дүнг нэгтгэж, үр дүнг тооцож дүгнэсэн үзүүлэлт байхгүй байв. Энэ нь тэдний ажлын уялдаа холбоо, мэдээллийн солилцоо дутмаг, хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллагуудын оролцоог тодорхойлсон эрх зүйн акт хангалтгүй байгаатай холбоотой бөгөөд үдийн цай хөтөлбөрийн үр дүнг тооцож, цаашид авах арга хэмжээг тодорхойлох боломжгүй юм.

Тиймээс үдийн цай хөтөлбөрийн үр дүнг тооцох, цаашид анхаарах асуудлыг тодорхойлох зорилгоор аймгийн хэмжээнд уг хөтөлбөр хэрэгжсэнээр хүүхдийн бие бялдар, эрүүл мэнд, сурлагын амжилтад гарсан өөрчлөлтийг нэгтгэн тайлагнах хугацаа болон ажлыг хариуцах байгууллага, албан тушаалтны ажлын уялдааг тодорхой зааж өгөх талаар дээд шатны байгууллагаар дамжуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд санал хүргүүллээ.

Үдийн цай хөтөлбөр хэрэгжсэнээр суралцагчдад ямар ахиц, дэвшил гарсан талаар багш нараас санал асуулга авлаа.



Санал асуулгаар нийт 61 багшийн 39.3 хувь буюу 24 нь “Идэвх сайжирсан” гэсэн бол 55.7 хувь буюу 34 нь орлого багатай өрхөд дэм болсон гэж үзжээ.

Харин сурлагын чанар сайжирсан гэж 2 багш хариулсан нь нийт судалгаанд хамрагдсан багш нарын дөнгөж 3.27 хувийг эзэлж байна.

Суралцагчдад үдийн цай

өгснөөр суралцагчдын хичээлийн ирц, идэвх оролцоо нэмэгдсэн талаар судалгаа авахад 16 сургууль “Тийм”, 2 сургууль “Үгүй” гэж хариулсан.

Хүүхдүүдийн өндөр, биеийн жинг сургуулиуд тогтмол хэмжсэн боловч суралцагчдын бие бялдрын өөрчлөлт, үр дүнг тооцож цаашид анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохгүй байна. Энэ нь сургуулийн эмч нар санаачлагагүй ажиллаж байгаатай холбоотой байна.

Хүснэгт 6

№	Сургуулийн нэрс	Үдийн цайнд хамрагдсан хүүхдийн тоо	Жингийн илүүдэлтэй хүүхдийн тоо	Жингийн дутагдалтай хүүхдийн тоо
1	Хулд	141	56	12
2	Луус	96	6	19
3	Дэлгэрцогт	73	3	6
4	Дэлгэрхангай	231	12	33
5	Говийн ирээдүй цогцолбор сургууль	475	3	2
6	Сайнцагаан 3-р сургууль	330	6	0
7	Эрдмийн далай цогцолбор сургууль	614	8	33
8	Мандал сургууль	440	34	0
<b>Дүн</b>		<b>2400</b>	<b>128</b>	<b>105</b>

Аудитын явцад 8 сургуулийн 2400 хүүхдийн хүрээнд хоолны тусгай дэглэм мөрдвөл зохих хүүхдийн талаар судалгаа авахад 128 хүүхэд буюу 5.3 хувь нь “Таргалалттай” 105 буюу 4.4 хувь нь “Тураалтай” гэж гарсан. Энэ судалгааг эмч нар гаргасан боловч эдгээр хүүхдүүдэд тогтмол арга хэмжээ авч өөрчлөлт, үр дүнг тэмдэглэж, цаашид анхаарах асуудлыг тодорхойлоогүй байна. (Хүснэгт 7)

Мөн суралцагчдын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл болон тусгай дэглэм баримталбал зохих хүүхдийн бүртгэл, судалгаа, өвчлөлийн шалтгаан, ямар төрлийн хоол, бүтээгдэхүүн хэрэглэвэл зохистойг тогтоосон талаарх мэдээлэл, цаашид анхаарах асуудлыг тодорхойлсон баримт материал байхгүй байна.

Энэ нь үдийн цай хөтөлбөрийг суралцагчдын эрүүл мэнд, бие бялдрын хөгжилтэй уялдуулан зохион байгуулахгүй байх сөрөг үр дагавартай юм.

Аймгийн Эрүүл мэндийн газраас сургуулийн насны хүүхдүүдийн дунд гарсан голлох өвчлөлийн судалгааг гаргуулав. (Хүснэгт 7)


Хүснэгт 7

Өвчлөлийн бүлэг	Бодит тоо	6-10 насны 10000 хүүхдэд харьцуулснаар
Амьсгалын тогтолцооны өвчлөл	313	744.7
Хоол шингээх эрхтний өвчлөл	129	306.9
Чих ба хөхөнцөрийн өвчлөл	47	99.9
Арьс ба халимны өвчин	31	73.7
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчлөл	24	57.1


Өвчлөлийн судалгаа аймгийн хэмжээнд хийгдсэн боловч түүнд таарсан хоолны цэсийг сургуулиуд зохиохгүй байна.

Тиймээс сургуулиуд хүүхдийн өвчлөлийг бүртгэж, шалтгааныг тогтоон, үдийн цайны цэс зохиохдоо анхаарах, гэртээ идвэл зохистой хоол хүнсний талаар зөвлөж байх шаардлагатай байна.





Үдийн цай хөтөлбөр хэрэгжсэнээр ахиц, дэвшил гарсан гэдэгтэй санал нийлэх үү? гэсэн асуулгад 1148 эцэг эх хариулснаас 753 нь буюу 65.5 хувь нь “Бүрэн санал нийлнэ” гэсэн бол 395 нь “Зарим талаар санал нийлэхгүй” гэж хариулжээ. Эндээс санал нийлэхгүй байгаа 395 эцэг эхийн шалтгааныг тодруулах зорилгоор дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна.



Хэдийгээр үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд сэтгэл ханамжгүй байдаг ч эдгээр 395 эцэг эхчүүдийн 54 хувь нь “Цаашид үргэлжлүүлэх шаардлагатай” гэсэн бол 40 хувь нь “Сайжруулан хэрэгжүүлэх хэрэгтэй”, үлдсэн 6 хувь нь “Үргэлжлүүлэх шаардлагагүй” гэсэн байна. 261 буюу 66 хувь нь өрхийн амьжиргаанд нэмэр болдог гэсэн хариулт өгчээ.

Багш нар, сургуулийн үйлчилгээний ажилтнууд үдийн цай хөтөлбөрт ямар чухал үүрэгтэй оролцдогийг Бүлэг 2.1-т харуулсан бол эцэг, эхчүүд хүүхдийнхээ эрүүл мэндэд хир анхаарал тавьдаг болохыг энэ үзүүлэлтээс харж болно.



Судалгаанд хамрагдсан нийт суралцагчдын **31.9 хувь нь** өглөө хичээлд явахдаа цай уудаггүй байна. Энэ нь тийм бага тоо биш юм.

Багш, эцэг, эхчүүдтэй хийсэн уулзалт, тэднээс авсан санал асуулгын дүн, бодит байдлаас харахад үдийн цай хөтөлбөрийг сайжруулан хэрэгжүүлэх нийгмийн шаардлага байгааг илтгэж байна.

Иймд ЕБС-дад хэрэгжүүлж буй үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх болон нийгмийн зүгээс гарч байгаа мэдээлэлд тулгуурлан цаашид улам сайжруулах арга хэмжээг эрх зүйн зохицуулалтаар бүрэн шийдвэрлэх шаардлага урган гарч байна.

### 3.2 Үдийн цайны чанарт тавих хяналтад эцэг эхийн оролцоо хангалтгүй байна.

Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлж буй 18 сургуулиас Дэрэн, Сайхан-Овоо, Цагаандэлгэр, Дэлгэрхангай сумдаас бусад 14 сургууль хяналтын комисс байгуулж ажилласан байна. Албан ёсоор хяналтын комисс байгуулагдаагүй ч дээрх 4 сумын хувьд дотоод хяналтын нэгж, тухай бүр ажлын хэсэг томилон хяналтыг гүйцэтгүүлж ажиллажээ.

Дэрэн, Сайхан-Овоо, Цагаандэлгэр, Дэлгэрхангай сумдын сургуулиудад журамд заасны дагуу хяналтын комисс байгуулах талаар зөвлөмж хүргүүлжээ.

Хяналтын комисс үдийн цай хөтөлбөрийн явцад хяналт хийдэг боловч хөтөлбөрийн үр дүнг тооцох, эцэг эхчүүдэд танилцуулан санал тайлбарыг авч, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхгүй байна. Энэ нь нэг талаас эцэг, эхийн оролцоо муу байгаатай холбоотой.

Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх журмын 6.1<sup>1</sup>-д заасан хамтарсан шалгалт огт хийгдээгүй байна.

Харин аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2015 онд 11 сургууль, 2016 онд 9 сургуульд төлөвлөгөөт хяналт шалгалт хийжээ.



Хүүхдүүд өөрийн эрүүл мэндэд ямар хүнсний зүйл сайн болохыг мэддэг боловч эцэг, эхийн төлөөлөл үдийн цай хөтөлбөр болон эрүүл хооллолтын талаарх ойлголт дутмаг болох нь ярилцлагаас харагдаж байв.

Тухайлбал эцэг эхчүүд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам, ямар төрлийн хоол хүнс өгдөг, хүүхэд өдөрт нийт ямар хэмжээний илчлэг авах ёстой, үүнээс хэдийг өглөөний цайгаар авах ёстой зэрэг асуултуудад “Мэдэхгүй” гэсэн хариулт өгч байсан.

<sup>1</sup>/“Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн болон Боловсрол, соёлын газар, мэргэжлийн хяналтын байгууллага хамтран хяналт тавина./

Хүүхэд өдөрт авах нийт илчлэгийн 10-15 хувийг үдийн цай хөтөлбөрөөр, үлдэж буй хувийг гэртээ идэж буй хүнсний зүйлээр дамжуулан авна. Тиймээс эцэг, эхчүүд үдийн цай хөтөлбөр болон эрүүл хооллолтын талаарх мэдлэгтэй болсноор үдийн цай хөтөлбөр илүү үр дүнтэй хэрэгжих боломжтой юм.

*Олон улсын жишээ:*

*Баруун Австрали:*

- 1. Эрүүл хооллолтын үзүүлэн гаргаж нийт сургуулийн хүмүүсийг урьж оролцуулан амьдралын суурь чадварыг хөгжүүлэх.*
- 2. Бага сургуулийн суралцагчид болон тэдгээрийн эцэг эхэд жимс, хүнсний ногоо идэх болон өдөр болгон ус уухын ач холбогдлыг таниулахад чиглэсэн Crunch& Sip нэртэй хөтөлбөр байдаг.*

*Баруун Австрали:*

*Хүнсний тэжээллэг байдлын талаар хичээл зааж эрүүл хооллолтын зуршлыг сайжруулах талаар сургуулийн бодлогод тусгасан байдаг.*

Улаанбаатар хотын 84 дүгээр сургууль эцэг, эхийн анхаарлыг татахуйц үдийн цай хөтөлбөрийн мэдээллийн самбарыг сургуулийн үүдэнд байрлуулсан байдаг. Тус самбарт 2 долоо хоногт олгох хоол, түүний зургийг илчлэг, эрдэс бодисын мэдээллийг харуулдаг байна.

Сургуулийн зүгээс хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам, эрүүл, зөв хооллолтын ач холбогдлын талаар эцэг, эх, хүүхэд, багш нарт сонирхолтой байдлаар сурталчлан таниулах, нэгдсэн ойлголттой болгох ажлыг тогтмол зохион байгуулах зэргээр сайн туршлагыг нэвтрүүлэх хэрэгтэй.

*Олон улсын жишээ:*

*Их британи:*

- 1. Шинэхэн жимсийг хүүхдэд өгөхдөө жимстэй тараг болон эрдэнэ шишийн ундаанд хольж өглөөний цайнд болон бага үдийн цайны завсарлагааны үеэр хөнгөн зууш байдлаар өгч болно. Түүнчлэн жимсний салат болон гадил жимсний хачиртай талхыг үдийн хоолны дараа амттан байдлаар хэрэглэж болно.*
- 2. Ус бол хүүхдийн амны цангааг тайлах хамгийн сайн ундаа юм. Тиймээс хүүхдийн ам цангах үед аль болох ус уулгаж сургах хэрэгтэй. Мөн жимсний цэвэр шүүс байж болно.*
- 3. Энерги, тос, ханасан өөх, уураг, нүүрс төрөгч, элсэн чихэр, төмөр, цайр, кальци, витамин А, С зэргийн сургуулийн хоолонд байх ёстой хэмжээг зааж өгдөг.*

## ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

“Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитаас Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд уламжлуулахаар ҮАГ-т дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Судалгаа шинжилгээнд тулгуурлан үдийн цай хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлсон баримт бичгийг боловсруулж гаргах
2. Үдийн цай хөтөлбөрийн хүрээнд мөрдөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, одоо мөрдөж байгаа журмыг хянан үзэж, сайжруулан өөрчлөх. Үүнд:
  - Үдийн цай хөтөлбөр үдийн хоол байдлаар хэрэгжиж байгаатай холбоотой журамд өөрчлөлт оруулах;
  - Үдийн цай хөтөлбөрийн үр дүнг тооцох, цаашид анхаарах асуудлыг тодорхойлох зорилгоор аймгийн хэмжээнд уг хөтөлбөр хэрэгжсэнээр хүүхдийн бие бялдар, эрүүл мэнд, сурлагын амжилтад гарсан өөрчлөлтийг нэгтгэн тайлагнах хугацаа болон ажлыг хариуцах байгууллага, албан тушаалтны ажлын уялдааг тодорхой зааж өгөх
  - Үдийн хоол өгч байгаа тохиолдолд хугацааг уртасгах зохицуулалт хийх;
3. Өрхийн амьжиргааны түвшинд үндэслэн үдийн цайны зардлыг ялгаатай байдлаар эцэг, эхээс гаргуулах боломжийг судлах.
4. Хүүхдийн тоонд үндэслэн олон хүүхэдтэй сургуульд туслах тогоочтой болгох арга замыг судалж, шийдвэрлэх;

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Үдийн цай хөтөлбөрийн төлөвлөлтийн судалгааг үндэслэлтэй хийж, гүйцэтгэлийг үнэн зөв бодитой тооцож тайлагнасан байна.
2. Хоол бэлтгэж буй газар болон хооллох орчин стандарт, эрүүл ахуйн шаардлага хангаагүй байна.
3. Хүнсний бүтээгдэхүүн стандарт, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа боловч татан авалтыг өдөр бүр хийх боломжгүйгээс шалтгаалж бүтээгдэхүүний хадгалалтын горим алдагдах эрсдэл байна.
4. Үдийн цайг үдийн хоол болгон хэрэгжүүлсэн нь оновчтой шийдэл боловч эрх зүйн орчин бүрдээгүй байна.
5. Үдийн цай хөтөлбөрийг цаашид сайжруулан хэрэгжүүлэх шаардлага байгаа ч сургуулиудад тоног төхөөрөмж дутмаг байна.
6. Хүүхдүүдийн өндөр, биеийн жинг сургуулиуд тогтмол хэмжсэн боловч суралцагчдын бие бялдрын өөрчлөлт, үр дүнг тооцож цаашид анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохгүй байна.
7. Үдийн цайны чанарт аймгийн Мэргэжлийн хяналтын газар хяналт хийсэн, мэргэжлийн байгууллагуудын хамтарсан хяналт хийгдээгүй байна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн холбогдох албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

### **Боловсрол, соёлын газарт:**

1. Үдийн цай хөтөлбөрийг оновчтой зохион байгуулан хэрэгжүүлж байгаа сургуулиудын туршлагыг судлан, бусад сургуулиудад нэвтрүүлэх талаар арга хэмжээ авах ;
2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох салбар (эрүүл мэнд, мэргэжлийн хяналт)-ын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор тогтмол хянах;

### **Сумдын багийн иргэдийн Нийтийн хуралд:**

1. Хооллох заалыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах жагсаалтад оруулах, эцэг, эхчүүдэд энэ талаар тайлбарлан таниулах,

### **Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газарт:**

1. Үдийн цай хөтөлбөртэй холбоотой тендер шалгаруулалтыг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах боломжийг хайх,

### **Хүнс, хөдөө аж ахуйн газарт:**

1. Орон нутагт жижиг дунд үйлдвэрийг дэмжих бодлогыг үдийн цай хөтөлбөртэй уялдуулах арга хэмжээ авах,

### **Ерөнхий боловсролын сургуулиудад:**

1. Хулд сумын сургууль, Сайнцагаан сумын 3 дугаар сургууль орон тооны тогооч ажиллуулах боломжийг судлах;
2. Багшийн ажлын ачааллыг бууруулах зорилгоор үдийн цай тараах, хооллох орчны эрүүл ахуйг хангах ажилд эцэг, эх болон суралцагчдын оролцоог нэмэгдүүлж, хяналт тавих ажлыг зохион байгуулах;
3. Сургууль бүр хоолны тусгай дэглэм баримталбал зохих хүүхэд болон суралцагсдын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, түүний шалтгааны талаарх мэдээллийг бүртгэж, үдийн цайны цэс зохиохдоо анхаарах, хүүхдүүдэд зохистой зөв хооллох зөвлөгөө өгөх
4. Сургуулийн зүгээс хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам, эрүүл, зөв хооллолтын ач холбогдлын талаар эцэг, эх, хүүхэд, багш нарт сонирхолтой байдлаар сурталчлан таниулах, нэгдсэн ойлголттой болгох ажлыг тогтмол зохион байгуулах;
5. Дэрэн, Сайхан-Овоо, Цагаандэлгэр, Дэлгэрхангай сумдын ерөнхий боловсролын сургуулиуд журамд заасны дагуу хяналтын комисс байгуулж ажиллуулах.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-д заагдсан байдлыг хангах үүрэг бүхий болон төрийн хөрөнгийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд оруулах нэмэлт санал, тайлбар байхгүй талаар мэдэгдсэн.

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БОЛОВСРОЛ СОЁЛЫН ГАЗАР

48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг

2016.11.21 № 253

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АУДИТЫН ГАЗАРТ

“Үдийн цай хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд нэмэлт санал тайлбар байхгүй бөгөөд сумдын сургуулиудад өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах боломжтой гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА  Ц.БУМАНГЭРЭЛ



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/34

Мандалговь

Гүйцэтгэлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 121 дүгээр тушаал, Гүйцэтгэлийн аудитын журмын 12.40-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалгаар, Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, батлагдсан удирдамж, хөтөлбөрийн дагуу “Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ДУАГ-НАБ/2016/01-НА/ -г баталсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. “Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний Аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Аймгийн Засаг дарга, Боловсрол, соёлын газарт тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг дахин давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнг 2017 оны 01 дүгээр сарын 20-ны дотор хариу мэдэгдэхийг аймгийн Боловсрол, соёлын газар болон аймаг, сумдын сургуулиудад зөвлөсүгэй.

5. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2017 оны 1 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, гүйцэтгэлийн аудитын багийн ахлах шинжээч /Ч.Бэрхсайхан/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ОУНЧИМЭГ



D:\office\tushaal\A4\Үдийн цай.docx

3900000071





Дундговь аймгийн Аудитын газрын  
тэргүүлэх аудиторын 2016 оны 11 дүгээр сарын  
25- ны өдрийн А/34 дугаар тушаалын хавсралт

**АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ**

Аудитын код: ДУАГ-НАБ/2016/01-НА  
Аудитын нэр: “Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудит

№	Аудитаар илэрсэн асуудал /Зөрчлийн товч утга /	Зөрчигдсөн хуулийн заалт	Зөрчлийн дүн төгрөгөөр	Үүнээс					Үр өгөөжийн	
				Аудитын явцад баригдуулсан	Акт тавигдсан	Албан шаардлага өрсөн	Зөвлөмжөөр өрсөн	Тоо	Мөнгөн дүн	
1	2016 оны 1-6 сарын хооронд 88 кг махыг анхан шатны баримтгүй, бараа материалын тайланд шууд зарлагдаж мах дутагдуулсан.	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 /баглагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/-т, Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 /хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуу ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;	366,740	-	366,740	-	-	1	366,740	

<p>1. Нягтлан бодох бүртгэл хөтөлөлт, анхан шатны баримтын бүрдэлтийг түүвэрлэн шалгахад 2016 оны 5 сарын 17-20, 31 өдрүүдийн хүүхдийн ирцийн бүртгэл, 2016 оны 06 сарын 3-ны өдрийн хоолны ордер байхгүй.</p>	<p>Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./, тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 /хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуу ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;</p>	<p>104,080</p>	<p>104,080</p>	<p>1</p>	<p>104,080</p>
<p>2. Багшийн журналтай үдийн цайны хүүхдийн ирцийн бүртгэлийг тулгаж үзэхэд сарын сүүлийн өдрүүд болон хүүхдийн амралтын өдрүүдэд хүүхдийн тоог нэмэгдүүлж бүртгэн, бодит ирцээс 148 хүүхдийг илүү бүртгэсэн.</p>		<p>470,820</p>	<p>366,740</p>	<p>2</p>	<p>470,820</p>
	<p><b>Нийт дүн</b></p>				

АУДИТЫН ГАЗАР

## ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД

Хавсралт №1

## Аймгийн хэмжээнд 1-5-р ангийн суралцагчдын өрхийн амьжиргааны түвшний судалгаа

№	Сургуулийн нэрс	Нийт 1-5-р ангийн хүүхдийн тоо	Амьжиргааны түвшний орлоготой айл өрхөд хамаарах хүүхдийн тоо	Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой айл өрхөд хамаарах хүүхдийн тоо	Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой айл өрхөд хамаарах хүүхдийн хувиар
1	Хулд	145	93	52	35.9 хувь
2	Луус	99	77	22	22.2 хувь
3	Адаацаг	184	129	55	29.9 хувь
4	Баянжаргалан	93	88	5	5.4 хувь
5	Говь-Угтаал	111	95	16	14.4 хувь
6	Гурвансайхан	150	132	18	12.0 хувь
7	Дэлгэрцогт	73	52	21	28.8 хувь
8	Дэрэн	142	69	74	52.1 хувь
9	Дэлгэрхангай	235	183	52	22.1 хувь
10	Сайхан-овоо	161	53	107	66.5 хувь
11	Эрдэнэдалай	608	547	61	10.0 хувь
12	Өлзийт	75	70	5	6.7 хувь
13	Өндөршил	122	97	25	20.5 хувь
14	Цагаандэлгэр	53	32	21	39.6 хувь

15	Говийн ирээдүй цогцолбор сургууль	483	369	114	23.6 хувь
16	Сайнцагаан 3-р сургууль	330	225	105	31.8 хувь
17	Эрдмийн далай цогцолбор сургууль	613	588	25	4.1 хувь
18	Мандал сургууль	440	380	60	13.6 хувь
	Нийт	<b>4117</b>	<b>3279</b>	<b>838</b>	20.4 хувь

**Сургуулийн хоол хүнсний материалын үнийг хооронд нь болон зах зээлийн үнэтэй харьцуулсан судалгаа**

Сургуулийн нэрс	Мах	Гурил	Будаа	Ургам- лын тос	Сахар	Масло	Сүү	Хуурай сүү	Төмс	Лууван	Сонгино	Байцаа
Дэрэн сумын сургууль	3700	1000	2100	2900	1400	3000	2700				1100	
Дэлгэрцогт сумын сургууль	3300	1400	2400	3500	1600	4000	2000		700	1100	3000	800
Сайхан-овоо сумын сургууль	5500	1500	2400	3800	2400	3500	1500		1000	1700	1700	
Дэлгэрхангай сумын сургууль	4500	980	1960	2950	2100	2950	2000		600	650	950	600
Хулд сумын сургууль	8000	1800	2500		2000			12000	800	1000	900	500
Луус сумын сургууль	4500	980	1920	3200	2100	3200	2000		600	600	1600	650
ЭДЦС		980	1980	2950	1450	2600	2300		950	1450	1200	1100
ГИЦС	4300	1120	1980	2950	1450	2800	1800		950	1800	1300	1600
СЦ 3-р сургууль	3300	1250	2300	3500	2250	3300	2500	8200	800	800	2000, 1500	800
Мандал	3500		1920		2100	3200	1800		600	600	1600	900
Номгон		980	2200	3300	2700		2200		600	800	1400	900
Цоглог		1200	2500	3500	2500		2400		800	1300	1200	800
Жавхлан		1300	2200	3400	2300	4500	2400		700	900	1100, 1900	1000
Махны зах	4600											

## Мэргэжлийн хяналтын газраас 2015-2016 оны хооронд үдийн цайн хоол хүнсний шинжилгээний дүгнэлт

Хоолны нэр төрөл	Дүгнэлт гаргасан огноо	Сахар, хувь	Давс, хувь	Хуурай бодис, гр	Эрдэс бодис, гр	Өөх тос, гр	Илчлэг, ккал	Илчлэг нийт ккал
Шар будаа	2016.02.24		0.2	65.8	1.3	8.61	302.5	563.8
Үзэмний шүүс		12		29.5	1.7		140.2	
Боов		6		26.6	0.2	3.1	121.1	
Аарц	2016.02.26			74.27	4.77	6.48	310	589.8
Өнгөт мөөхий		9.05					279.8	
Ногоотой зутан шөл	2016.02.26			58.41	4.59	43.29	431.7	543.65
Луувантай талх							111.95	
Жигнэсэн гурилтай шөл	2015.04.21			47	1.6	34.4	354	354
Аарц	2015.04.22			21.5	0.1	10	135.6	826.4
Ороомог				140	0.3	26.4	690.8	
Сүүтэй будаа	2015.05.06			57.1	0.51	5.44	253.6	594.4
Еэвэн				71.9	0.58	11.2	340.8	
Төмстэй шөл	2015.05.07			55.5	3.7	47.5	445.1	751.2
Бин				61.4	0.62	12.6	306.1	
Кашатай ингэний хоормог	2015.05.12			52.2	2.2	33.7	368.8	576.4
Кекс				34.4	0.58	13.7	207.6	
Гуляш	2015.05.15			91.55	3.37	30.2	503.8	503.8
Бантан	2015.05.12			29.8	1.6	24.6	235.6	235.6
								<b>553.905</b>